



НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2014 оны 05 сарын 27 өдөр

Дугаар А/35

Улаанбаатар хот


Жуулчны мэдээллийн төв байгуулах тухай

Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 16.5.5 дахь заалт, Соёл, спорт, аялал жуулчлалын сайдын 2014 оны А/104 дүгээр тушаал, нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2006 оны 49 дүгээр тогтоолоор батлагдсан “Улаанбаатар хотын аялал жуулчлал-2015” хөтөлбөрийн 2.1.2, нийслэлийн эдийн засаг, нийгмийн 2014 оны зорилтын 3.4.1.2, тус газрын дүрмийн 2.3, 2.7, 5.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. Нийслэлд аялал жуулчлал хөгжүүлэх, гадаадын иргэд жуулчдад Улаанбаатар хот, аялал жуулчлалын бусад бүсүүдийн талаар хэрэгцээт мэдээлэл, зөвлөгөө, туслалцаа үзүүлэх зорилгоор Улаанбаатар төмөр замын төв буудалд Жуулчны мэдээллийн төвийг Соёл, спорт, аялал жуулчлалын яамны дэмжлэгтэйгээр байгуулан 2014 оны 6 дугаар сарын 09-нөөс эхлэн ажиллуулсугай.


2. Жуулчны мэдээллийн төв байгуулах төсвийг хавсралт ёсоор баталж, шаардагдах 19.000.000 /арван есөн сая/ төгрөгийг холбогдох зардлаас тооцож гаргахыг ахлах нягтлан бодогч /П.Ариунаа/-д зөвшөөрсүгэй.

ДАРГА



Э.БАТТУЛГА

Нийслэлийн Аялал жуулчлалын
газрын даргын 2014 оны 05 сарын
27 өдрийн Адугаар тушаалын
хавсралт




Улаанбаатар төмөр замын төв буудалд
Жуулчны мэдээллийн төвбайгуулахад
шаардагдах зардлын төсөв

№	Зардлын зүйл	Тоо ширхэг	Нэгжийн үнэ /төгрөг/	Нийт үнэ/төгрөг/
1. Техник хэрэгслийн зардал				
1.1	Samsung LED телевизор 46 инч	1	1'499'990	1'499'990
1.2	Усны аппарат	1	199'990	199'990
1.3	Богино долгионы зуух	1	129'990	129'990
1.4	HP принтер /4 үйлдэлт/	1	449'900	449'900
1.5	Зөөврийн проектор	1	1'249'900	1'249'900
1.6	Dell I-7 7010-37 процессор	1	1'549'900	1'549'900
1.7	Dell I-5 7010 MT процессор	1	1'099'900	1'099'900
1.8	Dell- E 1914 дэлгэц	2	219'900	439'800
1.9	Холбооны зардал	2	346'000	792'000
1.10	Бичгийн хэрэгсэл	2	60'000	120'000
1.11	Гэрэл зургийн аппарат Canon 60D, дагалдах хэрэгслүүд	1	2'000'000	2'000'000
	Нийт			9'531'370
2. Түрээс				
2.1	Түрээсийн зардал/2014.03.03-2015.01.03/	10	300'000	3'000'000
	Нийт			3'000'000
3. Засвар, тохижилтын зардал				
3.1	Хана шохойдох, тааз солих, засварын материал	-	1.367.000	1.367.000
3.2	Явган хана хийх	-	380.000	380.000

3.3	Тавилга хийлгэх:			
	- 2 ширээ	2	320.000	320.000
	- Өлгүүр	1	190.000	190.000
	- Шүүгээ	2	335.000	335.000
3.4	Гадна хаяг хийлгэх /4 төрөл/	4	1.400.000	1.400.000
3.5	Мэдээллийн самбарын засвар, ашиглалт	6	1.831.630	1.831.630
3.6	Ширээ том /хийлгэх/	1	285.000	285.000
3.7	Газрын зураг хийлгэх /Монгол орны, Улаанбаатар хотын/	2	360.000	360.000
	Нийт			6.468.630
	БҮГД			19'000'000

Төсөв гаргасан: Мэргэжилтэн
Хянасан: Ахлах нягтлан бодогч



Э.Мөнхзул
П.Ариунаа